



ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ  
**ХОРООНЫ ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 01 өдөр

№ 09

Улаанбаатар хот

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ

“Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай” хуулийн 11.1.2 дугаар зүйл, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 23.2.5 дугаар зүйл, Монголбанкны Ерөнхийлөгчийн А-194, А-195 дугаар тушаал, Хадгаламжийн Даатгалын Үндэсний Хорооны 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголбанктай “Хөнгөлөлттэй хүүтэй зээлийн гэрээ”-г хавсралт нэгээр, “Хадгаламжийн даатгалын корпорацид санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээ”-г хавсралт хоёроор байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. Төрийн банктай “Хувьцаа худалдан авах гэрээ”-г хавсралт гурваар байгуулахыг зөвшөөрсүгэй.
3. Төрийн банкны “Хувьцаа худалдах худалдан авах гэрээ”-ний дагуу “Компанийн тухай хууль”-ийн 62 болон 34.1.1 дэх эрхийг Сангийн яаманд итгэмжлэлээр шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.
4. “Компанийн тухай хууль”-ийн 62 болон 34.1.1 дэх эрхийг итгэмжлэлээр шилжүүлэх гэрээг Сангийн яамтай байгуулахыг даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хадгаламжийн Даатгалын Корпораци (Б.Лхагвасүрэн)-д даалгасугай.

ДАРГА

  
Б.ЖАВХЛАН